



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ханх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

Мөрөн хот

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: О.Хосбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага.....	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АИТХТ	Аймгийн иргэдийг төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.09.25 № 01/176
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Д.АНХТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ханх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ханх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөг/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,527,980.25	50,365,166.29	
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	259,530.03	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	259,530.03	
3121	Төгрөг	00.00	259,530.03	
31211	Төрийн сангийн харилцах	00.00	259,529.03	
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	01.00	
33	АВЛАГА	36,551.00	4,084,322.00	
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	36,551.00	00.00	
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	3,939,100.00	
335	Бусад авлага	00.00	145,222.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	145,222.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	32,491,429.25	46,021,314.26	
351	Түүхий эд материал	17,381,863.75	35,521,675.25	
35110	Тусгай зориулалттай материал	2,637,500.00	00.00	
35130	Эм боох материал	14,744,363.75	35,521,675.25	
354	Хангамжийн материал	15,109,565.50	10,499,639.01	
35410	Бичиг хэргийн материал	612,000.00	619,640.00	
35420	Аж ахуйн материал	9,329,411.00	7,670,400.00	
35440	Түлш, шатах тослох материал	1,015,625.00	1,043,225.00	
35450	Барилгын засварын материал	261,500.00	261,500.00	
35460	Хүнсний материал	2,740,729.50	832,874.01	
35470	Бусад хангамжийн материал	1,150,300.00	72,000.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	320,007,497.79	368,669,198.97	
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	320,007,497.79	368,669,198.97	
392	Биет хөрөнгө	311,279,497.79	359,941,198.97	
39201	Барилга, байгууламж, орон сууц	257,038,230.00	256,524,340.00	
39202	Хуримтлагдсан элэгдэл	-44,446,488.48	-53,414,842.84	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	77,839,219.00	72,530,000.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25,796,906.19	-35,387,374.99	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,947,357.00	151,069,722.22	
39206	Хуримтлагдсан элэгдэл	-53,465,795.15	-49,336,139.72	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,744,960.00	24,657,915.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,581,078.39	-6,702,420.70	
393	Биет бус хөрөнгө	8,728,000.00	8,728,000.00	
39301	Програм хангамж	15,550,000.00	15,550,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	-15,550,000.00	-15,550,000.00	
39303	Бусад биет бус хөрөнгө	8,728,000.00	8,728,000.00	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	352,535,478.04	419,034,365.26	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	352,535,478.04	419,034,365.26	
51	Засгийн газрын хувь оролцоо	352,535,478.04	419,034,365.26	
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	288,330,820.00	288,330,820.00	
51101	Өмч: - төрийн	288,330,820.00	288,330,820.00	
512	Хуримтлагдсан үр дүн	-59,954,043.30	6,648,566.04	
51210	Өмнөх үеийн үр дүн	-59,954,043.30	-59,850,321.18	
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	66,498,887.22	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,158,701.34	124,054,979.22	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	352,535,478.04	419,034,365.27	

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/төгрөг/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	507,108,554.65	823,865,858.84	

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	455,229,294.65	274,989,368.84
120	Нийтлэг татварын бус орлого	89,439,494.65	274,989,368.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89,439,494.65	274,989,368.84
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	89,439,494.65	274,989,368.84
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	365,789,800.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	365,789,800.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,879,260.00	548,876,490.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	404,513,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	404,513,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,889,100.00	102,268,410.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	241,100.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,648,000.00	28,482,410.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	73,786,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,850,000.00	17,739,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	19,850,000.00	17,739,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28,140,160.00	24,355,180.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,140,160.00	24,355,180.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	475,691,622.15	756,443,689.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,691,622.15	756,443,689.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,683,533.15	713,143,689.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,613,969.00	291,699,553.55
210101	Үндсэн цалин	249,613,969.00	155,644,964.12
210102	Нэмэгдэл	00.00	91,766,808.33
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,118,000.00
210104	Урамшуулал	00.00	18,520,155.10
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	20,649,626.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,429,429.00	37,764,011.42
210201	Тэтгэврийн даатгал	24,313,967.00	27,147,552.54
210202	Тэтгэмжийн даатгал	3,061,205.00	2,663,782.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,238,960.00	2,131,026.06
210204	Ажилгүйдлийн даатгал	519,126.00	553,222.80
210205	Эрүүл мэндийн даатгал	5,296,171.00	5,268,427.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,078,251.00	13,216,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,753,876.00	1,800,000.00
210302	Түлш, халаалт	10,724,375.00	11,416,700.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,922,730.00	59,978,936.00
210401	Бичиг хэрэг	3,781,895.00	2,872,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,835,218.00	32,251,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,877,334.00	2,680,000.00
210404	Ном, хэвлэл	00.00	865,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	278,800.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,149,483.00	20,509,736.00
2105	Нормативт зардал	45,366,399.71	253,823,029.61
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,634,227.21	241,161,819.12
210502	Хоол, хүнс	7,732,172.50	12,661,210.49
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,324,442.00	7,995,000.00
210604	Урсгал засвар	18,324,442.00	7,995,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,083,000.00	2,115,300.00
210702	Дотоод албан томилолт	2,083,000.00	2,115,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,509,177.00	3,216,284.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,437,434.00	951,924.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,255.00	132,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,488.00	104,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	92,000.00	92,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	1,492,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,356,135.44	43,334,874.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,284,280.00	5,449,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	937,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,071,855.44	36,948,574.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,089.00	43,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	43,300,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	43,300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,089.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,089.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	31,416,932.50	67,422,169.64
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	923,282.42
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	923,282.42
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-923,282.42
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	31,416,932.50	66,498,887.22

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,330,820.00	-91,370,975.80	321,118,545.54
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	288,330,820.00	-91,370,975.80	321,118,545.54
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	26,909,647.79	26,909,647.79
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,330,820.00	-59,954,043.30	352,535,478.04
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,330,820.00	-59,954,043.30	352,535,478.04
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	103,722.12	103,722.12
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	288,330,820.00	-59,850,321.18	352,639,200.16
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-103,722.12
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	66,498,887.22	66,498,887.22
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	288,330,820.00	6,648,566.04	419,034,365.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	417,669,060.00	544,937,390.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	365,789,800.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	365,789,800.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	365,789,800.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	51,879,260.00	544,937,390.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	19,850,000.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	19,850,000.00	00.00

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	404,513,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,889,100.00	98,329,310.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	241,100.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,648,000.00	28,482,410.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	69,846,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	17,739,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	17,739,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28,140,160.00	24,355,180.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,140,160.00	24,355,180.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	417,669,060.00	521,348,059.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,669,060.00	521,348,059.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,660,971.00	478,048,059.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	255,870,083.00	290,248,928.97
210101	Үндсэн цалин	160,032,583.00	125,348,928.97
210102	Нэмэгдэл	80,257,500.00	100,900,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	6,300,000.00
210104	Урамшуулал	15,580,000.00	17,650,216.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	40,049,784.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,373,500.00	39,323,307.00
210201	Тэтгэврийн даатгал	24,188,800.00	27,600,958.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,546,200.00	2,917,873.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,036,900.00	2,385,197.00
210204	Ажилгүйдлийн даатгал	509,200.00	583,534.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,092,400.00	5,835,745.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,220,000.00	13,244,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,120,000.00	1,800,000.00
210302	Түлш, халаалт	7,500,000.00	11,444,300.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,739,028.00	43,549,200.00
210401	Бичиг хэрэг	2,587,500.00	2,872,000.00
210402	Тээвэр, шатахуун	24,469,094.00	32,251,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,877,334.00	2,680,000.00
210404	Ном, хэвлэл	108,400.00	865,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	278,800.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,417,900.00	4,080,000.00
2105	Нормативт зардал	32,036,200.00	71,540,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,600,000.00	58,286,745.00
210502	Хоол, хүнс	7,821,200.00	10,753,355.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,615,000.00	2,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,289,717.00	9,495,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,556,500.00	1,500,000.00
210602	Тавилга	985,000.00	00.00
210604	Урсгал засвар	10,748,217.00	7,995,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,083,000.00	2,115,300.00
210702	Дотоод албан томилолт	2,083,000.00	2,115,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,856,543.00	3,223,924.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,784,800.00	951,924.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,255.00	132,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,488.00	104,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	20,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	92,000.00	92,000.00

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,192,900.00	5,308,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,192,900.00	4,371,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	937,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,089.00	43,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	43,300,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	43,300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,089.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,089.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	23,589,330.03
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	23,329,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	23,329,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	23,329,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	23,329,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-23,329,800.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		259,530.03
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	259,530.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	450,212,800.0	446,348,551.0	3,864,249.0	99.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	450,212,800.0	446,348,551.0	3,864,249.0	99.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	450,212,800.0	446,348,551.0	3,864,249.0	99.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,018,300.0	283,481,672.0	1,536,628.0	99.5
210101	Үндсэн цалин	120,118,300.0	118,581,672.0	1,536,628.0	98.7
210102	Нэмэгдэл	100,900,000.0	100,900,000.0	00.0	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,300,000.0	6,300,000.0	00.0	100.0
210104	Урамшуулал	16,400,000.0	17,650,216.0	-1,250,216.0	107.6
210105	Гэрээт ажлын хөлс	41,300,000.0	40,049,784.0	1,250,216.0	97.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,477,400.0	38,477,400.0	00.0	100.0
210201	Тэтгэврийн даатгал	27,076,700.0	27,076,700.0	00.0	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,850,200.0	2,850,200.0	00.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,280,100.0	2,280,100.0	00.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	570,000.0	570,000.0	00.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,700,400.0	5,700,400.0	00.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,754,500.0	9,744,500.0	2,010,000.0	82.9

210301	Гэрэл, цахилгаан	3,810,000.0	1,800,000.0	2,010,000.0	47.2
210302	Түлш, халаалт	7,944,500.0	7,944,500.0	00.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	39,938,300.0	39,935,955.0	2,345.0	100.0
210401	Бичиг хэрэг	2,872,000.0	2,872,000.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	28,679,700.0	28,678,555.0	1,145.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,640,000.0	2,640,000.0	00.0	100.0
210404	Ном, хэвлэл	866,600.0	865,400.0	1,200.0	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.0	800,000.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,080,000.0	4,080,000.0	00.0	100.0
2105	Нормативт зардал	34,974,000.0	34,974,000.0	00.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25,234,200.0	25,234,200.0	00.0	100.0
210502	Хоол, хүнс	7,239,800.0	7,239,800.0	00.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.0	2,500,000.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,033,300.0	30,024,800.0	-1,991,500.0	107.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,499,800.0	9,499,800.0	00.0	100.0
210602	Тавилга	11,048,000.0	11,030,000.0	18,000.0	99.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.0	1,500,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	5,985,500.0	7,995,000.0	-2,009,500.0	133.6
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.0	2,115,300.0	384,700.0	84.6
210702	Дотоод албан томилолт	2,500,000.0	2,115,300.0	384,700.0	84.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,224,000.0	3,223,924.0	76.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	952,000.0	951,924.0	76.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	400,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	132,000.0	132,000.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,000.0	104,000.0	00.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.0	44,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	92,000.0	92,000.0	00.0	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.0	1,500,000.0	00.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,293,000.0	4,371,000.0	1,922,000.0	69.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,293,000.0	4,371,000.0	1,922,000.0	69.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	450,212,800.0	446,608,080.0	3,604,720.0	99.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	404,513,400.0	404,513,400.0	00.0	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	404,513,400.0	404,513,400.0	00.0	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,740,000.0	17,739,500.0	500.0	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	27,959,400.0	24,355,180.0	3,604,220.0	87.1
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,959,400.0	24,355,180.0	3,604,220.0	87.1

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	259,529.03	-259,529.0	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	00.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,329,309.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,329,309.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,029,309.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,767,257.00	
210101	Үндсэн цалин	6,767,257.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	845,907.00	
210201	Тэтгэврийн даатгал	524,258.00	
210202	Тэтгэмжийн даатгал	67,673.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	105,097.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	13,534.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	135,345.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,499,800.00	
210302	Түлш, халаалт	3,499,800.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	3,613,245.00	
210402	Тээвэр, шатахуун	3,573,245.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,000.00	
2105	Нормативт зардал	36,566,100.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,052,545.00	
210502	Хоол, хүнс	3,513,555.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,800,000.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,800,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	937,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	937,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,300,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,300,000.00	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	43,300,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	98,329,310.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,329,310.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,482,410.00	
131106	Төсвийн урамшуулал	69,846,900.00	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ханх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, Нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн анхан шатны баримтын бүрдэлт, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой албан шаардлага, зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор О.Хосбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Ханх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төгс суурь стандарт аудит ХХК-нд 2022 оны 02 дугаар сарын 23-ний өдөр хуулийн хугацаа хоцроож ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Ханх сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан, ил тод хүртээмжтэй үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан, ард иргэдэд эрүүл зөв амьдрах дадал үйлийг оновчтой тэгш хүртээмжтэйгээр хүргэж, орон нутгийн иргэдийн дундаж наслалт, амьдралын чадамжийг уртасгах, халдварын эрсдэлийг багасган, хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулж ажиллах зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Ханх сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх
- Сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа Санхүү, Нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/A/268 дугаар тушаалаар Ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- “Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Ковид-19-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ханх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 216.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 756.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 11.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр тогтоолоо. Энэ нь суурь үзүүлэлтийн дүн өмнөх оноос өссөнтэй холбоотой байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ханх сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 66.5 сая төгрөгөөр буюу 18.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0.26	0.26
Дансны авлага	0.04	4.08	4.05
Бараа материал	32.49	46.02	13.53
Биет хөрөнгө	320.01	368.67	48.66
Нийт хөрөнгө	352.54	419.03	66.50
Эздийн өмч	288.33	288.33	-
-төрийн	288.33	288.33	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	124.16	124.05	(0.10)
Хуримтлагдсан үр дүн	(59.95)	6.65	66.40
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	352.54	419.03	66.50

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь 0.3 сая төгрөг болж өссөн байна. Үүнд нөлөөлсөн материаллаг өөрчлөлт нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс үлдсэн хэмнэлтээс шалтгаалжээ.

Авлагын үлдэгдэл 4.1 сая төгрөг болж 4.0 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь ЭМДС-аас авах нэмэлт санхүүжилтийн авлага 3.9 сая төгрөг, Ханх ЭМТ-ын үйлдвэрчний эвлэлийн хороо данс руу 0.1 сая төгрөгийн 2 удаа шилжүүлснээс үүссэн илүү тооцооны авлагаас шалтгаалжээ. Тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 46.0 сая төгрөг болж 13.5 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд нөлөөлсөн материаллаг өөрчлөлт нь:

- Төсвийн хөрөнгөөр 139.6 сая төгрөгийн бараа материал худалдан авсан.
- Аймгийн ЭМГ-аас 211.8 сая төгрөгийн вакцин, эм тариа, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл хандиваар авсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 368.7 сая төгрөг болж 48.6 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд нөлөөлсөн материаллаг өөрчлөлт нь:

- Төсвийн хөрөнгөөр 23.3 сая төгрөгөөр машин тоног төхөөрөмж болон тавилга эд хогшил авсан худалдан авсан.
- Аймгийн ОНӨГ-ын даргын А/91, А/90, А/107, А/116 тушаал болон иргэдээс мөн ЭМГ-ын даргын тушаалаар МонПен төслийн хүрээнд 53.0 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил хандиваар авсан.
- Сумын ЗДТГ-аас 10.0 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан.
- Сумын ИТХ -ын тэргүүлэгчдийн 38 дугаар тогтоолоор 0.5 сая төгрөгийн барилга байгууламж, 5.3 сая төгрөгийн авто машин, элэгдлийн өртгөө бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй 43 нэр төрлийн 16.5 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 23 нэр төрлийн 7.9 сая төгрөгийн тавилга эд хогшил акталж данснаас хассан .

Хуримтлагдсан үр дүн 6.7 сая төгрөг болж 66.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 6.7 сая төгрөг болж 66.4 төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Нийт зардал нь өнгөрсөн оноос 280.7 сая төгрөгөөр өссөн байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 42 сая төгрөг, нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.3 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 138.4 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 13.0 сая төгрөг, норматив зардал 208.4 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 10.0 сая төгрөг, томилолтын зардал 32.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 12.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг нийт зарлагыг 450.2 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвөөс 404.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 17.7 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 27.9 сая төгрөг нийт 450.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 зориулалт бүхий арга хэмжээг санхүүжүүлэхээр 450.2 сая төгрөгийн санхүүжилт авч цалин хөлс нэмэгдэл урамшуулал 283.4 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 38.4 сая төгрөг байр ашиглалттай холбоотой 9.7 сая төгрөг, хангамж бараа материал 39.9 сая төгрөг, норматив зардал 34.9 сая төгрөг, тавилга эд хогшил 30.0 сая төгрөг, томилолтын зардал 2.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 3.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4.3 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, 3.6 сая төгрөгөөр дутуу санхүүжиж, 0.2 сая төгрөг төсөвт байгууллагын харилцах дансанд үлдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь дээд шатны төсвийн захирагчаас 28.4 сая төгрөг, ЭМД-ын сангаас 69.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 6.7 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 0.8 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 3.6 сая төгрөг, норматив зардалд 36.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 0.9 сая төгрөг, эд хогшил урсгал засвар 2.8 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 3.4 сая төгрөг, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 43.3 сая төгрөг нийт сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал. Үүнд:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Ковидын тархалттай холбогдсон Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ ихээхэн нэмэгдсэн. Ковидоор 160 хүн өвчилж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан, дархлаажуулалтаар 4165 тун вакцинд иргэдийг хамруулж, нийт 20.8 сая төгрөгийн зардал гаргаж нэхэмжилснээс 18.8 сая төгрөгийн санхүүжилт авч ЭМД-ын сангаас 3.9 сая төгрөгийн авлагатай гарсан.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх ёстой.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Ханх сумын эрүүл мэндийн төвийн 2021 онд нийт 526.6 сая төгрөгийн 40 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 217.0 сая төгрөгийн 29 мэдээллийг ил тод байршуулж, 378.3 сая төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.5, 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-н мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар биет бус болон үндсэн хөрөнгөтэй холбоотой 107.4 сая төгрөгийн нэг зөвлөмж, ашиглагдахгүй биет бус хөрөнгөтэй холбоотой 15.0 сая төгрөгийн 1 зөвлөмж, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж нийт 3 зөвлөмж өгсөн байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн биет болон үндсэн хөрөнгөтэй холбоотой 1 зөвлөмж, ашиглагдахгүй биет бус хөрөнгөтэй холбоотой 1 зөвлөмж нийт 2 зөвлөмж хэрэгжиж, шилэн дансны цахим хуудсанд 40 мэдээг хугацаа хоцроож, өгсөн зөвлөмжийн зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 788.3 сая төгрөгийн 21 алдаа зөрчил илэрснээс, 410.0 сая төгрөгийн алдааг залруулж, 378.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүү байдлын тайлангийн түлш, шатах тослох материал дансны үлдэгдлийг 0.1 сая төгрөгөөр,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан дээр тайлант үеийн цэвэр ашиг 0.1 сая төгрөгөөр,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрийг 409.0 сая төгрөгөөр,
- Бараа материалын тодруулга тайланд 0.6 сая төгрөгөөр тус тус илүү тайлагнасныг аудитын явцад залруулав.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Хөвсгөл аймгийн Ханх сумын эрүүл мэндийн төв нь өмнөх оны аудитын зөвлөмжөөр шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 378.3 сая төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь байна. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.5, 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ”, “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-н мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлан хоцроосон

Хөвсгөл аймгийн Ханх сумын эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч нь санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр заасан байтал 2022 оны 02 сарын 23 санхүүгийн тайлан балансаа ирүүлсэн. Энэ нь “Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1. “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” зөрчиж байгаа тул Хөвсгөл аймгийн Ханх сумын эрүүл мэндийн төвийн удирдлагад хариуцлага тооцуулах саналтай байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ханх сумын эрүүл мэндийн төв	3	788.3	1	410.0	-	-	1	378.3	0	0